



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2015 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 6/21

Улаанбаатар

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Авто тээврийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3, Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.5, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6, 8 дугаар зүйлийн 8.3.3, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1.Нийтийн тээврийн салбарт “Цахим төлбөрийн карт”-ын систем нэвтрүүлсэнтэй холбоотойгоор “Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сурагч, оюутанд нийтийн тээврийн цахим төлбөрийн карт олгох, цэнэглэх, ашиглахад баримтлах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийтийн тээврийн хэрэгслээр зорчих цахим төлбөрийн карт олгох журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Журмыг хэрэгжүүлэхэд холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2010 оны 6/51 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтийн тээврийн хэрэгслээр хичээлдээ зайлшгүй явах шаардлагатай сурагч, оюутныг тээвэрлэх журам”, 212 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих эрх бүхий иргэдийн нөхөн олговрыг хуваарилах, санхүүжүүлэх журам”-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Зох

ДАРГА

Д.БАТТУЛГА

06.11.2015

АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ  
ИРГЭДЭД НИЙТИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР  
ЗОРЧИХ “ЦАХИМ ТӨЛБӨРИЙН КАРТ” ОЛГОХ ЖУРАМ

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэхүү журмаар Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийтийн тээврийн хэрэгсэл (таксинаас бусад)-ээр үнэ төлбөргүй зорчих эрхийг нь хангаж нийтийн тээврийн хэрэгслээр үйлчлүүлэх цахим төлбөрийн карт олгох, гарсан зардлын санхүүжилттэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

**Хоёр. Нэр томъёо**

- 2.1. “Ахмад настан” гэж Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй Монгол Улсын иргэнийг;
- 2.2. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэж Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 10.2-т заасны дагуу аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх авсан Монгол улсын иргэнийг;
- 2.3. Нийтийн тээврийн хэрэгслээр зорчих “Цахим төлбөрийн карт” олгох эрх бүхий байгууллага гэж тухайн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагыг тус тус ойлгоно.

**Гурав. Нийтийн тээврийн хэрэгслээр зорчих ахмад  
настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх, үүрэг**

- 3.1. Энэхүү журмын 2.1, 2.2-т заасан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн тухайн жилд нийтийн тээврийн хэрэгслээр зорчих “Цахим төлбөрийн карт” авах ба дор дурьдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
  - 3.1.1. Нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих “Цахим төлбөрийн карт” захиалж мэдүүлэг бөглөх;
  - 3.1.2. “Цахим төлбөрийн карт”-ын үнийг төлөх;

- 3.1.3. гэмтэлтэй карт хүлээн авсан тохиолдолд тухайн картыг олгосон байгууллагад хүлээлгэн өгч үнэ төлбөргүйгээр солиулж авах;
  - 3.1.4. “Цахим төлбөрийн карт”-аа хаяж үрэгдүүлсэн тохиолдолд нэн даруй тухайн картыг олгосон байгууллагад мэдэгдэж бүртгэлээс хасуулж шинэ карт захиалж авах;
  - 3.1.5. нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих “Цахим төлбөрийн карт” захиалж аваагүй, картаа биедээ авч яваагүй, эсвэл хаяж үрэгдүүлсэн тохиолдолд энэхүү журмын дагуу захиалга өгч “Цахим төлбөрийн карт” авах хүртэл хугацаанд Авто тээврийн тухай хуулийн 11.2.6-д заасны дагуу тээвэрлэлтийн хөлсийг төлнө.
- 3.2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих “Цахим төлбөрийн карт”-ыг улирал бүрийн сүүлийн сарын 20-ны өдрийн дотор оршин сууж буй Хорооны байранд өөрийн биеэр очиж захиална.
  - 3.3. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас журмын 3.2-т заасны дагуу өөрийн биеэр очиж чадахгүй тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан захиалга өгч болно. Харин захиалсан картаа зөвхөн өөрийн биеэр хүлээн авна.
  - 3.4. Карт захиалсан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн энэхүү журмын 3.3-т заасны дагуу картаа хүлээн аваагүй тохиолдолд уг захиалга тухайн улирлын хувьд цуцлагдсанд тооцогдоно.
  - 3.5. Энэхүү журмын дагуу олгогдсон “Цахим төлбөрийн карт” ашиглаж нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчиж буй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийтийн тээврийн хэрэгслээр зорчихдоо иргэний үнэмлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэхээ биедээ авч явах ба эрх бүхий этгээдийн шаардсанаар бичиг баримтаа шалгуулах үүрэгтэй.

### **Дөрөв. Нутгийн захиргааны байгууллагын чиг үүрэг**

- 4.1. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих “Цахим төлбөрийн карт” олгох үйл ажиллагааг Нийслэлийн Нийгмийн Халамж үйлчилгээний газар хариуцан зохион байгуулах бөгөөд дор дурьдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.
  - 4.1.1. Улирал бүр Нийгмийн хамгаалал, халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, судалгааг авах;
  - 4.1.2. Дүүргийн Засаг даргын Тамгын газраас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, судалгааг улирал бүрийн сүүлийн сарын 20-ны өдрийн дотор гаргуулж авах;
  - 4.1.3. Энэхүү журмын 4.1.1, 4.1.2-т заасны дагуу эрх бүхий байгууллагуудаас авсан мэдээллийг нэгтгэн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүртгэлийн цахим сан бүрдүүлж, өөрчлөлт шинэчлэлтийг тухай бүр хийх;

- 4.1.4. ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих "Цахим төлбөрийн карт"-ын захиалга, мэдүүлгийг Хорооны засаг даргаар дамжуулан хүлээн авах;
  - 4.1.5. мэдүүлгийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хянан үзэж "Цахим төлбөрийн карт" авах шаардлага хангасан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд карт хүлээлгэн өгөх өдөр, цагийг мэдэгдэх /утсаар эсхүл цахим сүлжээгээр/;
  - 4.1.6. журмын 4.1.5-д заасны дагуу карт олгохоор мэдэгдсэн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоогоор "Цахим төлбөрийн карт" олгох эрх бүхий байгууллагад карт захиалах;
  - 4.1.7. "Цахим төлбөрийн карт"-ыг олгох;
  - 4.1.8. тухайн жилд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчуулахтай холбоотой гэрэх зардлыг тооцох, санхүүжилтийн асуудлыг тухайн жилийн төсөвт тусгуулах ажлыг хариуцан зохион байгуулах;
- 4.2. Хорооны Засаг дарга дор дурьдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 4.2.1. Хорооныхоо ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа хийх, бүртгэл хөтлөх;
  - 4.2.2. нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих "Цахим төлбөрийн карт"-ын захиалга хүлээн авч, мэдүүлэг бөглүүлэх;
  - 4.2.3. энэхүү журмын 3.2-т заасны дагуу "Цахим төлбөрийн карт" захиалсан иргэдийн бүртгэл, мэдүүлгийг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны өдрийн дотор нийслэлийн Нийгмийн халамж, үйлчилгээний газарт ирүүлнэ.
- 4.3. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих "Цахим төлбөрийн карт" олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Дүүргийн Засаг даргын Тамгын газар дор дурьдсан чиг үүрэгтэй оролцоно.
- 4.3.1. Энэ журмын 4.2.1-д заасны дагуу гарсан судалгаа, бүртгэлийг нэгтгэн улирал бүрийн сүүлийн сарын 20-ны өдрийн дотор Нийслэлийн нийгмийн халамж үйлчилгээний газарт хүргүүлэх;
  - 4.3.2. Журмын талаар сурталчлах, ойлгуулан таниулах ажил зохион байгуулна.
- 4.4. Нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих эрх бүхий ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нийтийн тээврийн хэрэгслээр зорчих "Цахим төлбөрийн карт" олгох үйл ажиллагааг нийслэлийн Нийгмийн халамж үйлчилгээний газар тухайн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах замаар хэрэгжүүлнэ.

**Тав. “Цахим төлбөрийн карт” олгох, цэнэглэх  
эрх бүхий байгууллагын чиг үүрэг**

- 5.1. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих “Цахим төлбөрийн карт” олгоход нийтийн тээврийн хэрэгслээр зорчих “Цахим төлбөрийн карт” олгох эрх бүхий байгууллага дор дурьдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 5.1.1. Хүлээн авсан захиалгын дагуу нутгийн захиргааны байгууллагад “Цахим төлбөрийн карт” хүлээлгэн өгөх;
  - 5.1.2. Тухайн жилд шаардлагатай “Цахим төлбөрийн карт”-ын нөөцтэй байх;
  - 5.1.3. Гэмтэлтэй карт олгогдсон тохиолдолд үнэ төлбөргүй сольж өгөх;
  - 5.1.4. Тухайн сард “Цахим төлбөрийн картаар” үнэ төлбөргүй зорчсон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчилтын тоо, гүйцэтгэлийг нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага тус бүрээр гаргаж, баталгаажуулсан тайланг дараа сарын эхний долоо хоногт багтаан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлнэ .

**Зургаа. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй  
иргэдийн нийтийн тээврийн хэрэгслээр зорчих  
зардлыг тооцох, нөхөн олговрыг санхүүжүүлэх**

- 6.1. Нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нийтийн тээврийн хэрэгслээр үйлчлүүлэх цахим төлбөрийн карт олгох, үнэ төлбөргүй зорчсонтой холбогдон гарах зардлыг Нийслэлийн Нийгмийн халамж үйлчилгээний газар тооцож, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн төсөвт тусгах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- 6.2. Тухайн жилд шаардагдах зардлыг тооцохдоо хяналтын тоо, зорчилтын тоо, насанд хүрсэн хүний зорчих тарифийг тус тус үндэслэнэ.
- 6.3. Нийслэлийн нийтийн тээврийн газар нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тариф өөрчлөгдсөн тухай бүрд холбогдох материалыг Нийгмийн халамж, үйлчилгээний газар болон тухайн мэдээлэл шаардлагатай бусад газруудад хүргүүлнэ.
- 6.4. Үйлчилгээний үнэ тарифын өөрчлөлттэй холбогдон нэмж шаардагдах хөрөнгийн асуудлыг Нийгмийн халамж, үйлчилгээний газар холбогдох эрх бүхий байгууллагад танилцуулж шуурхай шийдвэрлүүлнэ.
- 6.5. Энэхүү журмын 5.1.5-д заасны дагуу ирүүлсэн өмнөх сарын тайлан, гүйцэтгэлийг Санхүү, төрийн сангийн хэлтэс ажлын 5 хоногт багтаан хянаж, батлагдсан төсвийн хуваарийн дагуу “Цахим төлбөрийн карт” цэнэглэсэн байгууллагын дансанд шилжүүлнэ.
- 6.6. Энэхүү журмын дагуу ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих үйл ажиллагаатай холбоотой гарч

буй хөрөнгийн зарцуулалтад нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс хяналт тавина.

### Долоо. Бусад

- 7.1. “Цахим төлбөрийн карт”-ыг хуурамчаар үйлдсэн, бусдад дамжуулсан, хууль бусаар олгосон тохиолдолд хураан авч, буруутай этгээдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.
- 7.2. Журмын 3.1.4, 3.5-д заасан үүргээ биелүүлээгүй, картаа бусдад дамжуулсан зөрчил гаргасан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тухайн жилд дахин шинээр карт олгохгүй.
- 7.3. Энэхүү журамд зааснаас өөр байдлаар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих “Цахим төлбөрийн карт” олгохыг хориглоно.
- 7.4. Журмын 7.3-т заасныг зөрчиж карт олгогдсон тохиолдолд энэхүү журамд заасны дагуу нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөрийг нөхөн олгохгүй ба нөхөх олговортой холбоотой асуудлыг тухайн картыг захиалсан, олгосон байгууллага хариуцна.
- 7.5. Энэхүү журмаар хүлээсэн эрх үүргээ хангалтгүй биелүүлснээс үүсэн бий болох үр дагаврыг буруутай этгээд, байгууллага нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцна.

-----oO-----